141

# БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

20 17 .оны 03 дугаар сарын 15.-ны өдөр | Дугаар А/62 | Багануур

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

“Баганууурын дулааны станц” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Баганууурын дулааны станц” ТӨХК-ийн нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр.Журам батлагдсантай холбогдуулан байгууллагын нийт ажилтнуудад танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/Ч.Ариунбаатар/-д, дээрх журмыг мөрдөж ажиллахыг байгууллагын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ГАНБААТАР

Tushaal-2017

142

"Багануурын дулааны станц" ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2017 оны 05 сарын 15-ны
өдрийн 142 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

# "БАГАНУУРЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

**Зорилго:**

Компаний нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад ажилтан албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх далал, зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

**Удирдлага зохион байгуулалт:**

Компаний Гүйцэтгэх захирлын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулж хийх ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Хийсэн ажлын тайланг хагас жил тутамд дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн зөвлөлд хүргүүлэх, хэлэлцүүлэх, дүгнэлт гаргуулж цаашид хийх ажлын чиглэл авах.

Нийгмийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулан ажиллаж хамтын ажиллагааг сайжруулах

**Зөвлөлийн хийх ажлын чиглэл:**

Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, эрүүл ажлын байр бий болгох, архи, тамхигүй хамт олон болох талаар тодорхой ажил зохион байгуулах.

Ажиллагсдын бие бялдрын хөгжил, эрүүл мэндийн байдал, архи тамхины хэрэглээ, зонхилон тохиолдох өвчлөл зэрэгт судалгаа дүгнэлт хийх.

Ажиллагсдыг хөдөлгөөний хомсдлоос сэргийлэн нийтийн биеийн тамираар хичээллэх боломжийг бүрдүүлэн бие бялдрын хөгжил, эрүүл мэндийн байдлыг сайжруулах, архи тамхины хэрэглээг багасгах, зөв хооллолт, эрүүл мэндийн зөв дадал олгох талаар тодорхой ажил, сургалт сурталчилгааг зохион байгуулах.

Эрүүл амьдралын зөв дадал хэвшил эзэмшүүлэх талаар мэргэжлийн байгууллагатай хамтран сургалтын төлөвлөгөө гаргаж ажиллах.

Компаний ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа хамруулж, эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийн дагуу эрүүлжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртүүлэхгүй байх.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг /хөх, умайн хүзүүний хавдрын үзлэг, шинжилгээ, артерийн гипертензи, чихрийн шижин/-т хамрагдах ажилчдын судалгааг гарган хамруулах ажлыг зохион байгуулах

Салбар зөвлөл нь хагас жил тутам байгууллага хамт олондоо үйл ажиллагаагаа

тайлагнах, сурталчлах, идэвхи санаачлагатай ажилласан ажилтан, албан хаагчийг шагнал, урамшуулалд дэмжлэг үзүүлэх.

Биеийн тамир спортын хамтлаг байгуулах, нийтийн биеийн тамирын арга зүйч, чийрэгжүүлэлтийн танхим ажиллуулах.

**Салбар зөвлөлийн үйл ажиллагааг дүгнэх:**

Тайлан, төлөвлөгөөний биелэлтийг Захирлын зөвлөлд жилийн эцсээр дүгнүүлнэ.